



ӨМНӨГОВЬ АЙМАГ

ОРОН НУТГИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймгийн

2019 оны 6 ДУГААР сарын мэдээ

Нэг. Удирлага, зохион байгуулалтын хүрээнд

- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурал 6 дугаар сарын 11-нд хуралдаж 7 асуудал хэлэлцлээ. Үүнд:

- “Орлогод нийцсэн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам батлах тухай
- “Орлогод нийцсэн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Өмнөговь-Орон сууцны корпораци” ОНӨААТҮГ байгуулах, дүрэм батлах тухай
- Түгээмэл тархацтай хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх тухай
- Гашуун сухайт, Шивээ хүрэн хилийн боомтын чиглэлд нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй тээвэрлэлтийн нөхцөл шаардлага хангаагүй аж ахуйн нэгж байгууллагуудын эрхийг түтгэлзүүлэх талаарх 2018 оны 183 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг танилцуулах тухай
- Төрийн шагналд тодорхойлох, аймгийн ИТХ-ын шагналаар шагнах тухай
- Өмнөговь аймгийн харьяат бөхчүүдээс ирүүлсэн хүсэлтийг танилцуулах тухай
- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд 6 дугаар сарын 24-ний байдлаар ямар нэг өргөдөл гомдол бүртгэгдээгүй

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Төрийн шагналд тодорхойлсон 48 иргэний материалыг нягтлан шалгаж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд уламжилсан. Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар ирүүлсэн 19 иргэний материалыг нягтлан шалгаж захирамж гаргуулан сум байгууллагуудад хүргүүлсэнээр “Аймгийн Тэргүүний ажилтан” цол шагналаар 2 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг” –ээр 15 иргэн шагнууллаа. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож Төрийн албаны зөвлөлөөс баталж гаргасан журмуудыг сум байгууллагуудад цахимаар танилцууллаа. Төрийн албаны тухай хуулийн шинэтгэлийн үзэл баримтлалыг сурталчлах, холбогдох дүрэм, журмыг танилцуулан арга зүйгээр хангах “Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” сургалт, арга хэмжээнд сум байгууллагын 186 төрийн албан хаагчийг хамруулсан. Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн аймагт ажиллах үеийн ажлын төлөвлөгөөг гарган батлуулж агентлагуудыг шалгуулах, сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын нэрсийг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх сум байгууллагуудад зар хүргүүлэх ажлыг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч хэрэгжүүлсэн. Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдүүлэх чиглэлээр сум байгууллагуудад онлайн мэдээлэл хүргэжарг азүйгээр хангаж ажилласанаар 15 сум, 12 байгууллагын”Албан тушаалын тодорхойлолт”-ыг хянуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх удирдамж”-ийн дагуу хяналт шалгалт хийж зөвлөмж заавар өгөх ажлаар 15 сумын 57 байгууллага Даланзадгад сумын 4 сургууль, 1 байгууллага дээр ажилласан. Холбогдох дэд хөтөлбөр, тогтоол шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, Тамгын газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж хянуулсан

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 5-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн

гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа. 2. 2019 оны жилийн 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 43.2 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 36.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч орлогын төлөвлөгөө 84.0 хувийн биелэлттэй байна. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн. Хүсэлт ирүүлсэн Цогт-Овоо сумын цэцэрлэг, Цогтцэций сумын 6-р цэцэрлэг, Соёлын төв, ЗДТГазар, Ханхонгор сумын ЗДТГазар, Сум хөгжүүлэх сан, Гурвантэс сумын ЗДТГазар, Даланзадгад сумын ЗДТГазар, ОНХСан, Захирагчийн ажлын албаны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан Fiscal программаар өөрчлөлт оруулан сангийн яамны холбогдох мэргэжилтэнд илгээсэн. Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн Татварын хэлтэстэй хамтран “Төрийн сангийн төлбөр тооцоо ба Татварын удирдлагын нэгдсэн системийн сургалт”-ыг аймгийн төвийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, нярвуудад хийж нийт 90 гаруй хүн хамрагдлаа.

- ***Татвар төлөлтийн байдал***

ОНТХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн холбогдох материалын бүрдлийг хянан, санхүүжилтийн тооцоог хийж санхүүжилтийг олгож ажилласан бөгөөд 2019 оны 05 дугаар сарын байдлаар ОНХСангаас 2,179.5 сая төгрөгийн санхүүжилт, ОНТХОруулалтаас 12,225.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тус тус олгоод байна. 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбоотой 2019 оны 1-6 сард санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг гарган ашиглагч байгууллага болон захиалагч байгууллагын хөрөнгөнд бүртгүүлэх хөрөнгийн жагсаалтыг гарган ажиллаж байна. 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан байдлаар давхардсан тоогоор нийт 60 гаруй хөрөнгө оруулалтын ажлын 759,9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох ажлуудын чанарын баталгаа болгон гэрээнд тусгагдсаны дагуу суутган барьцаа хөрөнгө дансанд байршуулсан.

- ***Гурав. Хууль, эрх зүйн чиглэлээр***

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шалгалтад хамрагдаж холбогдох тайлан мэдээг гаргаж 1 өдрийн сургалтыг төрийн байгууллагын 150 албан хаагчдад зохион байгуулсан. АИТХ-ын даргын 2019 оны 32 дугаар Захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэйгээр төрийн болон төрийн өмчит нийт 54 байгууллагад хяналт – шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтыг - 3 төрлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерыг олон нийтийн сүлжээнээс тусгаарлах: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шинжилгээний алба, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хилийн 0131 дүгээр анги зэрэг нийт 54 байгууллагаас 20 байгууллага албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерыг олон нийтийн сүлжээнээс тусгаарласан бөгөөд үлдсэн 24 байгууллага тусгаарлаагүй хоройтой цахим хаягт нэвтэрдэг зөрчил илэрсэн. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, ашиглахыг хориглох Төрийн байгууллагын хүрээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Статистикийн хэлтэс, Даланзадгад дулааны цахилгаан түгээх станц зэрэг байгууллагуудын ажлын байран дээрээс архи согтууруулах ундаа хадгалсан зөрчил илэрсэн байна. Дотоод журмын өөрчлөлт оруулсан эсэх: Даланзадгад сумын сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газар, Гүний ус ХХК, Боловсрол, соёл урлагийн газар, байгууллага нэмэлт өөрчлөлт оруулаагүй. Аймгийн Цагдаагийн газартай хамтран “ОРОН НУТГИЙН ЗАМ-ХӨДӨЛГӨӨНИЙ СОЁЛ” аяны хүрээнд ЯАРААД ЯАХАВ ДЭЭ нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Энэ өдөр алба хаагчид Даланзадгад сумын хяналтын постонд 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж 164 тээврийн хэрэгсэл шалгаж, 164 жолоочид санамж, сэрэмжлүүлэг тараан "Яараад яахав дээ" нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Олон улсын түвшинд уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн “Торгоны зам” авто ралли уралдаан энэ оны 07 дугаар сарын 10- 12-ны

өдрүүдэд тус аймгийн Даланзадгад сумын нутагт барианд орох болсонтой холбогдуулан уралдаанд оролцож байгаа баг тамирчид, дагалдан яваа хүмүүс, үзэгч, зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- Боловсролын чиглэлээр

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг хангах АЗД-ын 2019 оны 03 дугаартай албан даалгаврыг гаргаж, хэрэгжүүлж ажиллалаа. Мөн бэлтгэл ажлын хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтын тандах шалгалтыг нийт 6 удаа авч, шалгалтын дүн мэдээнд дүгнэлт хийж, дүгнэлтийн дагуу Боловсрол, соёл, урлагийн газар, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарт үүрэг чиглэл өгч, давтлагын хуваарь гарган, хуваарийн дагуу давтлага хийж байна. Шалгалтыг 9 төрлөөр хичээлээр 128 хүүхдийг хамруулсан. 7 төрлийн хичээлээр 25 багш 40-60 цагийн давтлагыг 128 хүүхдэд өгч ажиллалаа.

2018-2019 хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалт 2019 оны 06 сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. 157 төгсөгч 10 төрлийн хичээлээр шалгалт өгсөн болно. Сургууль, цэцэрлэгүүдийг тоног төхөөрөмжөөр хангаж, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах ажлыг “Сүлдэт жороо” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж, хүлээлгэн өглөө. 56 төрлийн 183 ширхэг тоногт төхөөрөмжийг 8 сургууль, 1 цэцэрлэг, Боловсрол, соёл урлагийн газарт олгож, сургалтын орчин нөхцөлийн сайжруулан орон нутгийн төсвөөс 81.5 сая төгрөгийг зарцуулсан. Багшийн хөгжлийн төвийн барилгыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Хүннүгийн говь” ХХК-тай гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлж байна. Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн урлагийн заалны барилгыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Суварган говь” ХХК-тай гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлж байна. Хүрмэн сумын 80 хүүхдийн дотуур байрны барилгыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Оршдос” ХХК-тай гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлж байна. Аймгийн боловсролын чанарын тогтолцоог сайжруулах дунд хугацааны стратеги боловсруулах ажлын хүрээнд удирдах ажилтны удирдах арга барилгыг өөрчлөх дадлага, сургалтын арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн 80 удирдах ажилтныг хамруулан, мэдлэг боловсролыг нь нэмэгдүүллээ. Арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийг зарцуулсан.

- Эрүүл мэндийн чиглэлээр

Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийн дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Ханбогд, Гурван тэс, Цогтцэций, Даланзадгад сумдын хүн амд явуулын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ явуулын үзлэг оношилгоог Халдварт өвчин судлалын үндэсний төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч мэргэжилтгүүд хамтран зохион байгуулж байна. 2019 оны 06 сарын байдлаар Гурван тэс суманд үзлэг оношилгоо, эмчилгээний үйл ажиллагааг 10 хоногийн хугацаанд зохион байгуулж нийт 841 хүнийг хамруулж 2348 удаагын үзлэг, оношилгоо хийгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв дээр олон улсын байгууллагын 23,0 сая төгрөгний санхүүжилтээр эх барихын яаралтай тусламжийн өртөөчилсөн сургалтын өрөөг шинээр байгуулж, эрүүл мэндийн салбарын эх баригч бага эмч, эмэгтэйчүүдийн эмч нарт тоног төхөөрмжийн ашиглалт, ажлын байрны дагалдан сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Дадлага сургалтын өрөөг бий болгож, шаардлагатай мэдээлэл сургалт, сурталчилгааны багцтай болсоноор эх барихуйн тусламж үйлчилгээг үзүүлэгч, эмч, эх баригч нарт 2 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулаад байна. Сургалтын үр дүнд оролцогчдын мэдлэг, чадварын түвшин 20%-иар нэмэгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эрчимт эмчилгээний хэсэг 24 цагийн турш ЭХЭМҮТ-тэй холбогдон зөвлөх нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авах, хамтарсан үзлэг оношилгоо хийх боломж нөхцөлийг шинээр бүрдүүлсэн. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Эрүүл мэндийн яамны хамтарсан баг Өмнөговь аймгийн Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийж, зөвлөгөө зөвлөмжөөр ханган ажиллаа. Аудитын дүгнэлтээр Өмнөговь аймгийн Даланзадгад хотын усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилт 75.8 хувьтай, чанар сайн үнэлэгдсэн. Өмнөговь аймгийн "Эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих" нэгдсэн хөтөлбөрийг аймгийн ЗДТГазар, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, ДЭМБ, Австралийн Элчин сайдын яам, Говийн Оюу хөгжлийг дэмжих сантай хамтран 2018-2021 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа билээ. Төслийн удирдах хорооны хурлыг орон нутагт зохион байгуулж ЭМЯ, БСШУЯ, НХХЯ,

ДЭМБ, НҮБ-ийн Хүн амын сан, Хүүхдийн сан, Австралийн Элчин сайдын яам, Оюу толгой, Говийн Оюу хөгжлийг дэмжих сан зэрэг байгууллагын дарга удирдлага, төлөөлүүд оролцож хөтөлбөрийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж хэрэгжилтийг 53.2%-тай гэж дүгнэсэн.

- **Нийгмийн хамгааллын чиглэлээр**

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярыг Даланзадгад суманд 06 сарын 01-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Баярын арга хэмжээнд Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрыг урьж үзүүлэх тоглолт зохион байгуулсан бол Даланзадгад сумын албан байгууллагууд хүүхэд багачуудад зориулсан ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэн хамтран ажиллалаа. Аймгийн Засаг даргын гарын бэлгийг 1000 хүүхдэд, жолооч нарын холбоо хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхдэд гарын бэлэг гардуулан өглөө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах нөхцөл боомжийг бүрдүүлэх, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах зорилгоор “DZ-TRY-2019 арга хэмжээг Бие даан амьдрах төв, Түгээмэл төвтэй хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асарна хамгаалагч, хувийн туслах, сайн дурын ажилтнууд нийт 60 гаруй иргэн оролцлоо. Буянт хотхон хүүхдийн зуслан 2019 оны 06 сарын 09-ний өдөр эхний ээлжийн хүүхдүүдээ хүлээн авч үйл ажиллагаа эхлүүлсэн. Артек олон улсын хүүхдийн зуслантай хамтран Олон улсын хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг 2 дугаар ээлжээс эхлүүлж нимит 180 гаруй амрагч хүүхэд энэхүү хөтөлбөрт хамрагдаж байна. Артек олон улсын хүүхдийн зуслангаас 4 багш ирж ажиллаж байна. Хөгжлийн ирээдүй Оюунлаг залуучууд хөтөлбөрийн хүрээнд Гэрэлт гудамжид “Гадаа шатрын талбай” шинээр байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Цогтцэций суманд “Гэр бүлийн сэтгэл зүй” сургалтыг Гэр бүл судлаач, сэтгэл зүйч Г.Наранбаатартай хамтран амжилттай зохион байгууллаа. Дархан –Уул аймагт Жендэрийн эрх тэгш байдал бүсийн арга хэмжээнд Өмнөговь аймгаас НБХ, ГБХЗХГ, НТБТ-ийн захира, мэргэжилтнүүд нийт 4 хүн хамрагдаж Өмнөговь аймгийн “Уул уурхай дахь жендэрийн эрх тэгш байдал” арга туршлага үндэсний хэмжээнд хэрэгжих арга туршлагаар шалгарлаа.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

- **Газар тариалан**

Төмс, хүнсний ногооны тариалалт, ургацыг нэмэгдүүлж, хадгалж нөөцлөх боломжийг бүрдүүлэх зорилгоор "Төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь барих" төслийг орон нутгийн 379 327 021 төгрөгөөр хэрэгжүүлэхээр "Баяжих галуут" ХХК-тай гэрээ байгуулсан гүйцэтгүүлсэн ба зоорийн барилга угсралтын ажил бүрэн хийгдэж Улсын комисс ажиллуулан ашиглатад оруулах хүсэлтийг холбогдох газарт хүргүүлээд байна

- **Мал, аж ахуй**

5 дугаар сарын 11, 12-ны өдрүүдийн цасан шуурга, байгалийн гамшигт үзэгдлийн улмаас малын зүй бусын хорогдол ихээр гарч зооноз өвчин гарах эрсдэл үүсч байгаатай холбогдуулан Баяндалай, Булган, Сэврэй, Ханхонгор сумдад сэг зэм устгалын ажлыг зохион байгуулсан.

Сайханы сарлаг-2019" арга хэмжээг 8 дахь жилдээ Говь гурван сайхан уулын Ёлын аманд 2019 оны 5 дугаар сарын 25-нд амжилттай зохион байгууллаа. Өмнөговь аймгийн хэмжээнд 9 сумын 56 өрхөд 1241 сарлаг үхэр өсөн үржиж байгаа бөгөөд энэхүү баярт 5 сумын 26 өрхийн 750 сарлаг толгой сарлаг үхэр бүрт 5,0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгож, уралдаан тэмцээний тэргүүн байгуудад төсөвлөсөн шагнал урамшууллыг өгч ажилласан.

"Сайханы сарлаг-2019" уламжлалт арга хэмжээнд оролцогчид:

1. Сарлаг үхрийг уналга эдэлгээнд ашиглах, сургаж номхруулах
2. Сарлаг үхэр болон бусад малын сүү, цагаан идээ, ноос, ноолуур, аялал жуулчлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа
3. Сарлаг үхрийн зан үйлтэй холбоотой буухиа тэмцээн
4. Сарлагийн хөөвөр самнах
5. Сарлагийн шилмэл бух, үнээ шалгаруулах
6. Хамгийн сайхан тоног хэрэгсэлтэй, сайн гаршуулсан сарлаг шалгаруулах
7. Сарлагийн уралдаан
8. Оролцогчдын дунд хөгжөөнт тоглоом наадам зэргийг зохион байгуулж шилдгүүдийг шалгаруудан шагнаж урамшуулсан ба хамгийн зохион байгуулалттай оролцсон сумаар

Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газар шалгарлаа.

- **Жижиг, дунд үйлдвэрлэл**

ХХААХҮСайд ЖДҮХС, аймгийн Засаг дарга нар хамтарсан гэрээ байгуулж тус санд орон нутгийн төсөвт батлагдсан 3,0 тэрбум төгрөгийн хөрөнгийг байршуулан төсөл сонгон шалгаруулах дэд хорооны шийдвэрийн дагуу орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд сангийн журмаар зээл олгохоор төлөвлөн ажиллаж байна.

Мөн ХХААХҮЯамны сайдын 2019 оны А/41 дүгээр тушаалаар орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор хуваарилагдсан 1.0 тэрбум төгрөгөөс санхүүжин хэрэгжих төслийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг баримтлан батлагдсан жагсаалтад хамаарах төслүүдийг хүлээн авахаар нийтэд зарлан хүлээн аваад байна. энэ хугацаанд нийт орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 64 иргэн аж ахуй нэгж төсөл ирүүлээд байна..

- **Газрын харилцаа, хот байгуулалтын чиглэлээр**

Аймгийн Засаг даргын захирамжаар 1264 иргэний газрын өмчлөлтэй холбоотой шийдвэр гаргасан. Аймгийн Засаг даргын захирамжаар 13 иргэн, хуулийн этгээдэд газрыг шинээр буюу шинэчлэн эзэмшүүлсэн. "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд 15 сумын төвийн болон хот тосгон бусад суурины газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг боловсруулж батлуулах ажлыг эхлүүлэв. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах ажлыг эхлүүлэв. Даланзадгад сумын шинээр баригдаж буй цэвэрлэх байгууламжийг төв замтай холбогдох хатуу хучилттай авто зам"-ын зураг төсөл, төсөв боловсруулах ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажлыг эхлүүлэв. Сэврэй сумын Цэвэр, бохир усны шугам сүлжээний зураг төслийг ажлыг дуусган сонгон шалгаруулалтыг зарлав.

- **Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн чиглэлээр**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд аймгийн хэмжээнд шинээр хийгдэх барилга байгууламжийн санал тус бүрийн зардал үр дүнгийн шинжилгээ, холбогдох хувилбаруудын хамгийн бага зардлын шинжилгээ зэргийг хийж СЯ-аас хөтлөн явуулж буй цахим системд саналыг 2019 оны 06 сарын 01-ны дотор оруулан явууллаа. Аймгаас 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжих нийт 166,6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 73 төсөл арга хэмжээний саналыг холбогдох бүх яамдад хүргүүллээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийт 25,4 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр 31 ажлууд хийгдэж байна. Тус ажлуудын гүйцэтгэгчийг тодруулан гэрээг байгуулан, гүйцэтгүүлж байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам-ыг аймгийн ИТХ-ын 2019 оны 8/6 тогтоолоор шинэчлэн баталсны дагуу сумдад согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хүсэлтийг шийдэрлэж ажиллах чиглэлийг өгч, тус журмыг мөрдөн ажиллаж байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт 1-р улирлын байдлаар 30,5 хувийн биелэлттэй байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг тооцон гаргах ажлыг хийж гүйцэтгэж байна. Өмнөговь аймаг –Оюу толгой ХХК-ийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2019 оныг Хөдөө аж ахуй үйлдвэржилтийн жил, салбарын хувь соёлыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх саналыг аймгаас хүргүүлээд байна.

- **Зам тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 131 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг нүүрс тээврийн компаниудад хийсэн хяналт шалгалтаар тээвэрлэлтийн нөхцөл шаардлага хангаагүй нүүрс тээврийн компаниудад эрхийг түдгэлзүүлэх талаар ИТХ-ийн 2018 оны 183 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргад чиглэл өгсөн тухай тогтоолын хэрэгжилтийг 06 дугаар сарын 12-ны өдөр ИТХТ-д танилцуулах материалыг бэлтгэн, танилцуулав.

Мөн орон нутгийн болон хот, хот орчмын зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг өргөтгөн зохион байгуулах зорилгоор 5 суманд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байсныг 15 суманд үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөлийг судлан, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 , 8 дугаар

зүйлийн 8.4 дэх заалтыг үндэслэн орон нутгийн өмчийн дээрх компанид удирдлага зохион байгуулалтыг хариуцуулахаар 2019 оны 04-р сарын 18-ны өдөр А/385 тоот захирамж гарган ажиллаж байна. “Даланзадгад зорчигч тээвэр” ОНӨААТҮГ нь зорчигч үйлчилгээний төв, засвар үйлчилгээний төвийн барилга, үйлдвэрлэлийн бааз сууриар хангагдсан ба зорчигчдын бүртгэлийн цахим систем “Ти Ти Эс” программ ашиглан үйлчилгээгээ эхлүүлэхээр хүлээгдэж байна. Энэ талаарх албан бичгийг 2019-05-06-ны өдөр Авто тээврийн үндэсний төв хүргүүлсний дагуу Авто тээврийн үндэсний төвөөс тухайн зохион байгуулалтыг дэмжиж ажиллах талаар мэдэгдэл ирүүлсэн байна. Барилгын тухай хууль, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авч 6 аж ахуйн нэгжийн улсын комисс ажиллах захирамжийг гарган ГХБХБГ-г хүргүүлэв. Мөн ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ, Нийслэлийн зорчигч тээврийн газарт олгох захирамжийг төлөвлөн СТСХ-т тус тус хүргүүлсэн болно. Манлай сумдын цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлын гэрээг Алтан үндэс констракшн ХХК, Мандал-овоо сумын цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлын гэрээг Б-Софт ХХК, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн моторын барилга барих ажлыг “Чонон сүлд констракшн” ХХК-тай байгуулан, ажлыг эхлүүлсэн байна. Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг 06 дугаар сарын 20-ны өдөр цугларалт зохион байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан барилгын үйлдвэрлэл явуулж, хүний амь нас эрсдэх, гэмтэх бэртэхээс болгоомжлох талаар албан шаардлага хүргүүлэх, мөн үндэсний баяр наадамтай холбоотой Цэнгэлдэх хүрээлэнгийн урсгал засварыг хийх төсөв тооцоог гарган, тухайн уулзалтад оролцсон 20 ААНБ-д ажлыг хуваарилан засвар үйлчилгээг хийж байна. БХБЯ-нд Орон сууцны тухай хуулийн төсөл, 150 мянган айл-Орон сууц үндэсний хөтөлбөрийн төсөл, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийн өөрчлөлт зэрэгт санал хүргүүлсэн, мөн Өмнөговь дугаартай болгож, авто тээврийн хэрэгслийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Уул уурхайн ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д өөрчлөлт оруулах саналыг холбогдох агентлагуудаас хүлээн авч нэгтгэн ИТХ-д хүргүүлсэн. Хагас жилийн байдлаар Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тус тус гарган хугацаанд нь хүргүүлэв.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд
- Байгаль орчны чиглэлээр

МУ-ын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлиг, Байгаль орчин, Аялал жуулчлалын Сайдын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Бүх нийтээр мод тарих сарын ажлыг зохион байгуулах тухай” 04 дүгээр албан даалгавар, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Хайлаасны баяр зохион байгуулах тухай” 88 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын “Хайлаасны баяр бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах тухай” 04 тоот албан даалгаврыг боловсруулан баталж орон нутагт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. “Хайлаасны баяр, бүх нийтээр мод тарих ажил”-ын нээлтийн ар н Батмөнх даян хааны талбайд зохион байгуулж, ногоон байгууламж, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд тарьц суулгац, үр, үрсэлгээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулж оролцлоо. Хаврын мод тариалалтын арга хэмжээгээр 15 сумын хэмжээнд тариалах тарьц суулгацын хангамжийг орон нутгийн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газраас зохион байгуулж 15 суманд 8 төрлийн 40950 ширхэг тарьц суулгац, 24 байгууллага, аж ахуйн нэгжид мөн 8 төрлийн 17820 ширхэг тарьц, суулгацыг тус тус үнэгүй олгож, бусад суулгацыг мод үржүүлэгч аж ахуйн нэгж байгууллагууд бэлтгэн нийлүүлж тариалалтыг бүрэн хийж, усалгаа арчилгаа тордолгоонд сум орон нутаг анхаарал тавин ажиллаж байна. Бүх нийтийн мод тариалалтаар 15 сумын хэмжээнд 5447 иргэн, 280 ААН, байгууллага оролцож 661 өрх хашаандаа 8795 ширхэг мод, орчин тойрон, бичил цэцэрлэг, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн 1,06 га талбайд 39333 ширхэг мод, баг хороонд шинээр байгуулсан бичил цэцэрлэгийн 8,2 га талбай үүсгэж 6811 ширхэг мод, 470 м² талбайд зүлэгжүүлэлт, 400м² талбайд цэцгийн мандал тус тус тариалж нийт 64324 ширхэг мод бут сөөг тариалж ногоон байгууламжийн хэмжээг 9 га талбайгаар нэмэгдүүлээд байна. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.1.2, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/412 дугаар тушаалаар баталсан Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.1 дэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэж аймгийн Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөмж болгож буй арга зүй, шалгуурын дагуу хөндлөнгийн аудитын үнэлгээг Эрүүл мэндийн яамнаас 2019 оны 06 сарын 06-09-ны өдрүүдэд хийлээ. Хөндлөнгийн аудитын үнэлгээний хүрээнд УАБТ-тэй холбогдох 6 байгууллагын 20 хүнтэй уулзалтыг талбарт болон тухайн байгууллагад очиж танилцаж, багийн гишүүд, мэргэжилтэн ажилтнуудтай уулзалт ярилцлага хийсэн. Мөн ус хангамжийн тогтолцооны бүх үе шат болох ундны усны эх үүсвэр, усан сан, хлоржуулалт, түгээлт, УТБ байруудтай газар дээр нь очин биечлэн танилцаж, эрсдэл илрүүлэх, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны хяналт, удирдлагын горим зэрэг шалгуурын дагуу үнэлж, сайжруулах арга хэмжээ, шийдэл, арга замуудын зөвлөмжийг орон нутагт өгсөн. Хөндлөнгийн аудитаар Даланзадгад хотын УАБ-ын 2017-2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт 75.8 хувьтай, чанар сайн үнэлэгдэв. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2019 оны гэрээний хагас жилийн хэрэгжилтийг 52,6 хувийн биелэлттэйгээр дүгнэж аймгийн Засаг даргын 2019 оны 1-1587 тоот албан бичгээр хүргүүлэв. Уг гэрээгээр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 29 ажил арга хэмжээ төлөвлөснөөс 4 ажил арга хэмжээ хугацаа болоогүй, нийт хэрэгжилт 50,9 хувьтай, салбарын байгууллагуудын хэрэгжүүлэх 54 ажил арга хэмжээ төлөвлөснөөс 10 ажил арга хэмжээ хугацаа болоогүй, нийт хэрэгжилт 54,4 хувьтай хэрэгжүүлж хагас жилийн байдлаарх хэрэгжилт нийт дүнгээр 52,6 хувьтай хэрэгжүүлж байна. Монгол, Хятад, Орос гурван улсын нөөц баялагт тулгуурлан хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх үйлсэд өөрийн нутгийн түүх соёл, үзэсгэлэнт онгон байгаль, уламжлалт ёс заншил, ховор нандин олдворуудыг тус холбоогоор дамжуулан дэлхий нийтэд сурталчлан жуулчдыг татах, хойч үедээ өвлүүлж үлдээх, хадгалж хамгаалах, аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгон хөгжүүлэх зорилгоор “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын холбоонд Өмнөговь аймаг албан ёсоор гишүүнээр элсэж орох хүсэлтийг тус холбоотой зөвшилцөн аймгийн Засаг даргын 2019 оны 1-1287 тоот албан бичгээр хүргүүлсэн билээ. Үүнтэй холбоотойгоор “Цайны зам” соёл аялал жуулчлалын хөгжил шинэчлэлийн форум, “Цайны зам” соёл аялал жуулчлалын экспод оролцож гишүүн аймгийн батламж хүлээн авах урилгыг аймгийн Засаг даргад ирүүлсэн. Тус экспо 2019.06.22-27-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Улаан цав хотод зохион байгуулагдаж аймгийн төлөөлөлөөр ХОХБТХ-ийн дарга Ж.Сүх-Эрдэнэ, БОАЖГ-ын мэргэжилтэн Н.Бурмаа, Гайхамшигт говь аялал жуулчлалын холбооны гүйцэтгэх захирал Ариунсанаа нар оролцож байна. Дэлхийн цөлжилтийн өдрийг тохиолдуулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Оюутолгой ХХК-тай хамтран “Ургамал оршихуйд амьдрал оршино-2019” эрдэм шинжилгээний бага хурлыг 2019 оны 06 сарын 17,18-ны өдрүүдэд Даланзадгад хотноо зохион байгууллаа. Судлаач, докторууд, орон нутгийн төлөөлөл, эрдэм шинжилгээ болон уул уурхайн зарим компани, байгууллагууд гэсэн 40 гаруй эрдэмтэдийн төлөөлөл, оролцогч 100 орчим иргэд нийт 140 гаруй иргэдийг оролцуулан говийн бүсийн ургамлын аймгийг хамгаалах чиглэлээр туршлагаа хуваалцлаа. Манай аймаг нь уул уурхайн бүс нутаг гэдгээрээ онцлогтой тул ургамал устах, газрын хөрснөөс арчигдах зэрэг эрсдэлд хүрдэг байна. Иймд нэн ховор, унаган ургамлуудаа үржүүлэх, хамгаалж генийн санг нь авч үлдэх ажлыг хийх шаардлагатай байгааг судлаачид хэлж байлаа.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр

Засгийн газрын болон аймгийн ИТХ-ын шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж, албан даалгаврын 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд ХШҮ хийх удирдамжийг тус тусд гаргаж холбогдох нэгж, албан тушаалтнуудад хүргэсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн ХШҮ хийж тайлан дүгнэлтээ бичиж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болсон-100%, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийх ажил үргэлжилж байна-50%. Аймгийн ИТХ-ын 163 тогтоолын 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд ХШҮ хийх ажил үргэлжилж байна. 6 сарын 21-ний өдрөөр мэдээлэл хүлээн авах ажиллагаа дуусч ХШҮ хийх ажил эхлэнэ. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг холбогдох нэгж, албан тушаалтнууд

программд оруулах ажил үргэлжилж байна. Аймгийн Засаг даргын 467 захирамж, 5 албан даалгаврын хэрэгжилтэд ХШҮ хийх ажил явагдаж байна. Засгийн газрын шийдвэр 10, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 25, аймгийн Засаг даргын 219 захирамж, бүгд 254 шийдвэрийг хүлээн авч бүртгэн хяналтад авах, хариуцсан албан тушаалтанд хүргэх ажлыг хийлээ.

Хэлтсийн хамт олон дараах ажлын хэсэгт орж ажиллаж байна. Үүнд:

- Наадмын бэлтгэл хангах
- Албан тушаалын тодорхойлолт боловсруулах
- Архивын улсын үзлэгт бэлтгэх

Дараах нэгдсэн арга хэмжээнд оролцов

- ТАЗ-ийн нэгдсэн сургалт

Аймгийн Засаг даргын 2019 оны А/676 дугаар захирамжаар уг төлөвлөгөөг батлуулж хариуцан эхэргжүүлэх байгууллага, албан тушаалтанд хүргүүлээд байна.

Найм. Батлан хамгаалах чиглэлээр

Бэлэн байдлын “Цайдам” дохионы хадгалалт хамгаалалтыг 04-ний өдөр Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал шалгаж, шалгасан тухай тэмдэглэл хөтөлсөн. Илэрээн зөрчилгүй дохио хэвийн хадгалагдаж байна. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад шаардагдах аймгийн нутаг дэвсгэр, физик газарзүй, хүн ам зүй, эдийн засаг нийгмийн үзүүлэлтүүд, орон нутгийн цэргийг зэвсэглэхэд орон нутгаас гаргах зэвсэг, техник, галт хэрэгслийн тооцоо судалгаа, сум бүрийн томилгоот нэгж тус бүрээр зэвсэг хэрэгслийг тооцон гарган, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж батлуулахад батлуулахад бэлэн болгосон. Цэргийн штабын 2019 оны сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сумдын Батлан хамгаалах товчооны бүрэлдэхүүнд зарлан мэдээлэлтийг явуулж, бэлэн байдлын төлөвлөгөөний хавсралтууд болон оногдуулан данслагдсан хүн, автотехникт тодотгол хийлгэх, 2019 онд бэлтгэлээр халагдсан дайчдыг оногдуулан данслах зорилгоор сумдыг бэлэн байдлын дадлагын дохиогоор ажиллуулан дүгнэв. Монгол Улсын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам”-ын 2.1.4 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны а/182 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комиссын Цэргийн штабын дайчилгааны бичиг хэрэгт хадгалагдан ашиглагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц материал, баримт бичгийн 2019 оны эхний хагас жилийн тооллого, шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд явуулж, тооллогын актыг ЗХЖШ-ын БСТГ-ын дайчилгааны нууцад хүргүүлсэн. Нууц баримт бичиг, ном, материал алдаж үрэгдсэн зүйлгүй заавар, журмын дагуу хадгалагдан ашиглагдаж байна. 2019 оны эхний хагас жилд сумдад Батлан хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг авч дүгнэн, Батлан хамгаалахын сайд Өмнөговь аймгийн засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тооцож, аймгийн Цэргийн штабыг үнэлж дүгнэх журмын дагуу дотооддоо үнэлгээ хийж дүнг БХЯ-нд хүргүүлсэн. Батлан хамгаалахын сайдын 2016 оны а/88 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн штабыг шалгаж, үнэлэх журам”-ын дагуу дотооддоо штабын үйл ажиллагаа, төрийн нууц баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт, шалгалт үнэлгээ хийв. Ерөнхий үнэлгээгээр үр дүнг 91,6 хувь буюу 4,1 оноогоор үнэлэв. Төрийн албан хаагчийн 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, дүгнүүлсэн. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн орон нутагт хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдыг мэдээ, цэргийн дүйцүүлэхийн мөнгөн төлбөрийн 50 хувийн зарцуулалтын тайланг тус тус гаргаж, БХЯ-ны СБТГ-т хүргүүлсэн. БХЯ-ны БСТГ-аас ирүүлсэн албан даалгаврын дагуу “2020 онд Цэргийн дүйцүүлэх албыг биеэр орлуулан хаах иргэдийн тоо батлах” тухай Засгийн газрын тогтоолын төсөлд оруулах санал, Өмнөговь аймгийн 2020 оны цэргийн бүртгэлийг явуулах хугацааны санал, Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор баталсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын өөрчлөлтөд оруулах санал, Цэргийн штабын офицеруудын 2019 оны ээлжийн амралтын хуваариудыг БХЯ-ны СБТГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн орон нутгаас төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцох хүсэлтэй зам гүүр, инженерийн мэргэжилтэй эрэгтэй иргэдийн судалгаа, хугацаат цэргийн албыг түрүүч, ахлах түрүүч цолтой алба хаасан бэлтгэл үүрэгтнүүдийг судалгааг сумдаас авч, БХЯ-ны СБТГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын

мөрийн хөтөлбөрүүд болон 2019 онд аймгийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлууд, эхний хагас жилд батлан хамгаалах чиглэлээр гарсан захирамжийн хэрэгжилтийг гаргаж Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс, Хяналт, шинжилгээ үнэлгээний тасагт хүргүүлсэн. Иргэдээс цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа гаргуулахаар гаргасан 10 өргөдөл ирснийг Батлан хамгаалахын төв архивт, Хил хамгаалахын төв архивт албан бичгээр хүргүүлж шийдвэрлэсэн. Цэргийн штабаас 13 албан бичиг боловсруулан явуулж, бусад газраас 5 албан бичиг ирж, бичиг баримтыг бүртгэж холбогдох албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлсэн. Монгол улсын Ерөнхий сайд У:Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулагдсан төрийн цэргийн байгууллагуудад цэргийн алба хаасан үе еийн жагсаалын дарга, бага дарга нарын “ДУРСАМЖ, УУЛЗАЛТ” арга хэмжээнд Өмнөговь аймгийн сумдаас оролцох, нийт 11 бэлтгэл ахлах түрүүч, түрүүч нарын Даланзадгад сумаас Улаанбаатар хот руу явах унаа, хоолны зардлыг нь аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргуулж, унаагаар хүргэж, авч ирэх ажлыг зохион байгуулсан.

СУМДЫН МЭДЭЭ

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Засаг даргын Тамгын газрын даргын А Тушаал 6 гарсан байна. Засаг даргын А Захирамж 11 гарсан байна.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Сумын төрийн албан хаагчид болон сумын иргэдэд харилцаа хандлага, хүүхэд гэр бүлийн хөгжил сэдвээр нэг өдрийн сургалт, Төрийн сан статистикийн мэргэжилтэний хамт Хүн ам орон сууцны бэлтгэл ажлын сургалт, Мал тэжээвэр амьтад, хороо бууцны хагас жилийн түүвэр тооллого зохион байгуулах сургалт, Аймгийн Улаан загалмайн хороо, онцгой байдлын газрын мэргэжилнүүд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтуудад тус тус хамрагдав. Амийн ЗДТГ-н ХШҮДА-н хэлтсийн мэргэжилтнүүдийг сумандаа урьж ирүүлсэн төрийн байгууллагын ажилтан албан хаагчдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах арга зүй журмын талаар сургалтын зохион байгуулсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

2-р улирлын багуудын ИНХ-аа 5-р сарын 28-30-нд амжилттай зохион байгуулж сумын ЗДТГ-н албан хаагч мэргэжилтнүүд багуудад явуулын үйлчилгээ үзүүлж шинэ хууль эрхзүйн мэдээллүүдийг хийлээ.. Оюу толгой ХХК-ны хангамжийн хэлтэстэй хамтран орон нутгийн бизнес эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулж сумынхаа бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийлгэлээ. ХААН банкн дээр ХУР мэдээллийн системээр үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлж эхэллээ.

Татварын орлого бүрдүүлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөө 21813,2 мян/төг төвлөрүүлэхээс орсон орлого-94700,6 буюу 434,1 хувьтай хэрэгжиж байна. Аймагт төвлөрүүлэх орлого: Төлөвлөгөө 48624,8 мян/төг төвлөрүүлэхээс орсон орлого 79177,7 буюу 162,8 хувь, Улсын төсөвт бүрдүүлэх: Төлөвлөгөө 7645,0 мян.төг төвлөрүүлэхээс орсон орлого 11062,7 буюу 144,7 хувь гүйцэтгэлтэй. Багийн иргэд нийтийн хурлаар Налих-60, Могойт-90,Харзаг-70 нийт-220 малчдад “Малын эрүүл мэндийн тухай” хуулийг мэдээлэл хийв. Сумын төвийн дэлгүүр ААН-үүдэд” Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай “189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Гялгар уутны хэрэглээ багасган, даавуун уутаа хэрэглэе” гэсэн урааг байгууллагуудаар Байгаль хамгаалагч, Байгаль орчны мэргэжилтний хамт явж танилцуулан 16 ш гарын авлага тараасан. Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөл хуралдан Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний талаар албан байгууллагуудаар явж танилцлаа. ХХААГ-т хүлэмжийн блонк 5 ш захиалан авсан. ХХАА-н үйлдвэржилтийн жилийн хүрээнд малын эмч, хөдөө аж ахуйн мэргэжилтний

сургалтанд хамрагдав. Газар тариалангийн сургалтанд С.Отгонцэвээн, Б.Саранчимэг, Г.Балчинханд, Оюунчулуун, Б.Сарангэрэл нар сургалтад хамрагдав.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар Малчин өрхүүдийнхээ хаваржилтийн байдалтай танилцаж Налих, Могойт багийн айл өрхүүдээр явж төрийн үйлчилгээг хүргэлээ. Халх голын ялалтын 80 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны нээлтээ хилийн 0131-р ангийн Бүдүүн модны застав дээр очиж хийлээ.

Тав. Багт хийгдсэн ажил

2018 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөсөн гүн өрмийн худгуудаа Эрхэм сүлд ХХК Харзаг багийн малчин Р.Баярсайхан, Могойт багийн малчин Г.Ноов нарын гаргалаа. Мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээ цаг тухай бүрт нь авч гарган мэдээлж байна. Багийн малчин өрхүүдээр сумын Засаг даргын хамтаар явуулын үйлчилгээ үзүүллээ.

ДАЛАНЗАДГАД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргын А захирамж 48 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулах тухай-1, Буцалтгүй тусламж олгох тухай-6, Гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэх тухай-7, Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө зарцуулах тухай-9, Дэмжлэг үзүүлэх тухай-3, Шагнаж урамшуулах тухай-5, Хүүхэд үрчлэх тухай-1, 2019 оны төсвийн сар улирлын хуваарь өөрчлөн батлах тухай-1, Цахилгаан дамжуулах агаарын шугам байгуулах газрын байршил тогтоох тухай-1, Авто машины хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах тухай-1, Э.Отгонцэцэгт асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай-1, Ажил хүлээлцэх ажлын хэсэг томилох тухай-1, Тусгай зөвшөөрөл олгох тухай-1, Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж газар эзэмшүүлэх тухай-1, Ажлын хэсэг байгуулах тухай-4, Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай-1, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай-2, Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай-1,

Сумын Засаг даргын Б захирамж 2 Албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлэх тухай, В.Энхсолонгийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлөх тухай, Тамгын газрын даргын А тушаал 15 Ажлын хэсэг байгуулах тухай-6, Үнэлгээний хороо байгуулах тухай-1, “Нутгийн захиргааны байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт”-ийн сургалт, арга хэмжээний зардалд хөрөнгө зарцуулах тухай-1, Хөрөнгө зарцуулах тухай-3, Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1, Хэвлэмэл хуудас хариуцсан ажилтанг томилох тухай-1, Албан хэрэг хөтлөлтийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1, Ботгоны урамшуулал олгох тухай-1,

Б тушаал 4 С.Баярмаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулах тухай, Б.Цэнднадмидад буцалтгүй тусламж олгох тухай, Б.Ренчиндоржтой хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулах тухай, Х.Цоггэрэлийг ажилд томилох тухай

Хоёр.Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

2019 оны 06 сарын 02-нд Статистикийн хэлтсийн мэдээ тайлан гаргах сургалтанд ХАА-н мэргэжилтэн Ч.Дүүрэнжаргал хамрагдсан. 2019 оны 06 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 105 албан бичиг хүлээн авснаас 51 бичиг нь хариутай. Хариутай бичгийг заасан хугацаанд шийдвэрлэсэн. Засаг дарга болон Тамгын газраас 117 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Хариутай 51 хариугүй 54–105 23 санал хүсэлт өргөдөл ирсэн. 14 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хаасан, 9 өргөдөл хугацаандаа явж байна. 2019.05.29-30-нд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албанаас зохион байгуулсан “ШИНЭ БАГ” төслийн сургалтад 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд багийн 60 иргэн хамт хамрагдлаа. 2019.06.02-нд Статистикийн хэлтсийн мэдээ тайлан гаргах сургалтад Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, газар тариалан хариуцсан бодлогын мэргэжилтэн Ч.Дүүрэнжаргал хамрагдсан. 2019.06.05-06-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулагдсан “Ногоон байгууламж, Хог хаягдлын менежмент “Хангайн бүсийн аймгуудын нэгдсэн зөвлөгөөнд

Байгаль хамгаалагч Э.Нандинцэцэг хамрагдсан. 209.06.10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Эрүүл хотын сүлжээ олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулж буй "Эрүүл мэндийг дэмжих зан үйлийн өөрчлөлт" олон улсын сургалтад Эрүүл мэнд, спорт, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн Т.Ууганбаяр хамрагдлаа. 2019.06.14-нд "Хашаандаа сайхан амьдарья", "Утааг бууруулья", "Хогоо багасгая", "Жорлонгоо өөрчилъе" уриан доор "Царцаа Ногоон залуус" багийнхан Даланзадгад сумын Засаг даргын урилгаар хүрэлцэн ирж, сургалт хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Нийт 120 гаруй албан хаагч, иргэд оролцлоо. 2019.06.14-15-ны өдрүүдэд Үндэсний статистикийн хороо, аймгийн Статистикийн хэлтсээс зохион байгуулсан "Хүн ам орон сууцны тооллого болон хүн амын тоо"-ны сургалтад Засаг даргын орлогч, Статистик төрийн сангийн мэргэжилтэн, 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд хамрагдлаа. 2019.05.21-нд Аймгийн төв номын сантай хамтран ажиллах тухай сургалтад 8 багийн нийгмийн ажилтан хамрагдав. 2019.05.23-нд НТБ төвөөс зохион байгуулсан "Монголын нууц товчоо" номын хэлэлцүүлэгт 19 иргэн, нийгмийн ажилтны хамт оролцсон. 2019.05.24-нд Музейгээс зохион байгуулсан "Үлгэрийн цаг" үйл ажиллагаанд 8 багийн нийгмийн ажилтан 38 иргэний хамт амжилттай сайн оролцсон. 2019.05.24-нд Өмнөговь аймаг Даланзадгад сумын Засаг Даргын 2019.03.29 а/64 захирамжийн дагуу бүх нийтийн их их цэвэрлэгээ зохион байгуулж найман баг нийт 22 тн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлүүлэн хогийн цэгт төвлөрүүлсэн. Мөн багийн 16 алба хаагчид хариуцуулсан 48 ААН-ийнхээ орчны хог цэвэрлэгээ, ногоон байгууламж, тохижилтод хувиарын дагуу хяналт тавин тайланг хүргүүлэв. Байгууллагын шуурхай хурлыг 3 удаа хуралдаж цаг үеийн ажил, чиг үүргийг өгч ажиллаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Соёлын жилийн нээлтэд сумын ЗДТГ-ын албан хаагчид болон 8 багийн 260 гаруй иргэд соёл уламжлалаа илэрхийлсэн үзүүлбэртэй оролцож Их-Уулын 6 дугаар багийн "Улаан гэр" үзүүлбэр 1-р байр эзэллээ. Биеийн тамир спортын төрөлжсөн сургалттай 7-р сургуульд гадаад хэлний лингафоны кабинетыг иж бүрэн тохижуулан хүлээлгэн өглөө. Ерөнхий боловсролын 6 сургууль 100% лингафоны танхимтай боллоо. Сумын Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нартай "Хамтран ажиллах гэрээ" байгууллаа. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ИТХ, ЗДТГазар, Хотын захирагчийн ажлын алба, багийн Иргэдийн Нийтийн Хурлын хамт олон Даланзадгад сумын ИТХ, ЗДТГазар, Хотын захирагчийн ажлын алба, багийн Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа. Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн 80 жилийн ойг тохиолдуулан бүтээлч ажлыг эрчимжүүлэх зорилгоор 21 хоногийн хугацаатай "Хүмүүнлэг үйлсэд иргэн таны оролцоо" аяныг 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл зохион байгуулахаар Даланзадгад сумын Улаан загалмайн анхан шатны хорооноос эхлүүлсэн. Даланзадгад сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн ивээл дор сурагчдын спортын авьяас чадварыг нээн илрүүлэх, хамтач, нөхөрсөг, уур амьсгалыг бүрдүүлж, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг "НАЙДВАР ЛИГ-2019" өсвөрийн сагсан бөмбөгийн тэмцээн ахлах, дунд, бага насны ангиллаар амжилттай зохион байгуулагдаж шагналаа гардууллаа. Даланзадгад сумын зорилтот бүлгийн 80 өрхийн иргэдийг элэгний ВС вирусийн шинжилгээнд хамруулах ажлыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Төлчин хүүхэд 2019 оны үйл ажиллагааны хүрээнд 13 малчин өрхөд 26 хүүхэд тусалж мал маллах арга ухаанд суралцсан байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шөвөг ярын тарилга"-ыг 4390 төлд тарьсан байна. Паразитын арга хэмжээ боловсруулалтад 5100 мал, туулгалтанд 60 нохой, 320 мал хамрууллаа. 2 малчин өрхийн 450м2 малын хашаан талбайг ариутгасан байна. Мал эмнэлгийн үзлэгт 214 тэмээ, 49 адуу, 210 үхэр, 6460 хонь, 10280 ямаа, 5400 төл малыг хамрууллаа. Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Монгол цэргийн баярын төлөвлөгөө гарган 14 ажлыг зохион байгуулж 1400 гаруй иргэнийг хамруулан оролцууллаа. Нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад 24 иргэнийг оролцуулж хяналтыг тоог бүрэн биелүүллээ. Улс орон даяар зарлагддаг газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор Даланзадгад сумын Онцгой комисс, Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 99-н албан хаагч, аврагчдыг жагсааж бэлэн байдлын үзлэгт хамрууллаа. Гал унтраах 21 дүгээр ангитай хамтран "Галын тактикийн сургууль"-ийг зохион байгуулж, 16 байгууллагын 286 албан хаагч оролцлоо. 2019 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас "Сумын гэр хорооллын гэрэлтүүлгийн зураг төсөв боловсруулах", "Даланзадгад сумын услалтын

системийг засварлаж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх”, “Иргэний танхимын хөгжим, апартур, эд хогшлыг шинэчлэх”, “Соёл амралтын хүрээлэнд гүн өрмийн худаг гаргах” ажлуудын тендерийг цахимаар зохион байгууллаа. “Соёл амралтын хүрээлэнгийн ДП дэд өртөөг солих”, “Тамгын газрын 2,3 давхрын засвар”-ын ажлуудын техникийн комисс ажиллан ажлыг хүлээн авлаа. “Даланзадгад сумын гэр хорооллын гэрэлтүүлгийн ажил”-ыг хийж гүйцэтгүүлэхээр Номин Ендэрт ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүллээ. Мод үржүүлгийн 80 га талбайд аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолын дагуу хайлаасны баяр, бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд УЦУОШГазар, БОАЖГазар, АӨГСГЗахиргаа, ЗААлбаны ойн ангийн ажилчид сум дундын ойн ангийн нийт 80 гаруй албан хаагчид хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 3,2 тн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлээ.

Даланзадгад сумын төсвийн орлогын төлөвлөгөө 688720,9 мян.төгрөг гүйцэтгэл 520546,8 мян.төгрөг болж 75,6 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 2500,3 мян.төгрөг, гүйцэтгэл 5377,0 мян.төгрөг 239,1 хувьтай байна

Дөрөв. Багт хийгдсэн ажил

2019.05.27-нд Хариуцлагатай уул уурхай хэлэлцүүлэгт 8 багийн Засаг дарга 70 иргэний хамт оролцлоо. 2019.05.27-нд 8 багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үер усны холбоотой мэдээлэл, судалгааг сумын онцгой комисст хүргүүлж ажиллаа. 2019.06.14-нд “Даланзадгад хотын хөгжилд иргэдийн оролцоо” сэдэвт сургалтад 8 багийн 65 иргэнийг оролцууллаа. 1-р баг: 2019.05.26-нд 23-р цэцэрлэгт 2-5 нас, хөгжлийн бэрхшээлтэй 0-6 насны хүүхдүүдийн судалгааг гаргаж өгсөн. 2019.05.30-нд Аймгийн музейгээс амьжиргааны төвшин доогуур өрхийн 13 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гарын бэлэг гардуулсан. 2019.05.30-нд “Одонгоо зүүцгээ” одонтой ээжүүдийн баярын арга хэмжээг зохион байгуулж нийт 330 эмэгтэйчүүд оролцлоо. 2019.05.30-нд Аймгийн Засаг даргын гарын бэлгийг 50 хүүхдэд гардуулан ажиллаа. 2019.06.07-нд Аймгийн ИТХ-ийн төлөөлөгч, аймгийн засаг даргын орлогч Х.Батболд нартай хамтран багийн ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын уулзалтыг зохион байгууллаа. 2-р баг: 2019.05.25-нд “Бид нэгдэж байна” Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах ажлыг байгуулж, нийт 71 эмэгтэйчүүд оролцлоо. 2019.05.30-06.01 Хүүхдийн баярыг угтан БТСГ-тай хамтран 100 буудалт даамны тэмцээн болон ахмадуудын хүлээн авалтын үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 88 иргэн хамрагдлаа. 2019.05.31-нд Аймгийн Засаг даргын гарын бэлгийг багийн зорилтот бүлгийн өрхийн 50 хүүхдэд гардуулан өглөө. 3-р баг: 2019.06.01-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан багийн ААН болон аймгийн Засаг даргын гарын бэлгийг нийт 300 хүүхдэд гардуулан өглөө. 6-р баг: 2019.05.26-нд Сумын онцгой комисстой хамтран багийн үерийн цэгүүдтэй танилцан шуурхай ажиллаа. 2019.05.31-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын болон багийн ААН-ийн гарын бэлгийг 205 хүүхдэд гардуулж, багийн ээжүүдийн хүлээн авалтыг зохион байгуулж 2 ээжийг алдаршуулж алдрыг тэмдэглэн. Нийт 40 ээж оролцлоо. 2019.06.02-нд 4-р байрны СӨХ байгуулах талаар тус байрны 30 гаруй өрхийн төлөөлөлтэй уулзалтыг зохион байгууллаа. 7-р баг: 2019.05.21-нд Багийн иргэдийн дунд “Scatt” Буудлагын тэмцээнийг зохион байгууллаа. Нийт 54 иргэн оролцлоо. 2019.05.30-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ижий Шүтээн” хүндэтгэлийн арга хэмжээг 8 дугаар багтай хамтран зохион байгуулж, нийт 350 гаруй ээжүүд оролцлоо. 2019.06.01-нд “Оюутын-Одод” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 70 гаруй тамирчид оролцлоо. 2019.06.01-нд аймгийн Засаг даргын гарын бэлгийг багийн зорилтот бүлгийн 70 хүүхдэд гардуулан өглөө. 8-р баг: 2019.06.01-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын болон багийн ААН-ын гарын бэлгийг 115 хүүхдэд гардуулан өглөө..

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Ээлжит 08-р Хуралдаан товлон зарлах тухай хэлэлцэн баталж тогтоолын хувийг Сумын ЗДТГ-т хүргүүлэв. Тогтоол №88 Төрийн дээд шагналд иргэдийг тодорхойлох тухай. Монгол улсын төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны улаан туг одон”-оор шагнуулахаар Г.Наранбаатар, Монгол улсын “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор шагнуулахаар Ц.Цэцэгдэлгэр, “Цэргийн гавьяаны одон”-оор

шагнуулахаар М.Наранбаяр, Н.Төрбат, Ц.Өлзийбаатар “Цэргийн хүндэт медаль”-аар шагнуулахаар А.Төмөрмөнх, Д.Баасанбат, Б.Эрдэнэбаатар, Г.Баянмөнх, С.Амгаланжаргал, Ж.Энх-Амгалан, М.Сугирхүү, Д.Майдар, Н.Сэргэлэнбат, Т.Амартайван, З.Батсайхан, “Алтан гадас одон”-оор шагнуулахаар Д.Гомбосүрэн, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар Г.Амартүвшин нарын тодорхойлолтыг хуралд оролцсон Тэргүүлэгчид 100 хувийн саналаар дэмжиж Тогтоол № 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100,101,102,103,104,105,106,107,-г баталлаа. Сумын Засаг даргын А захирамж 48 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулах тухай-1, Буцалтгүй тусламж олгох тухай-6, Гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэх тухай-7, Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө зарцуулах тухай-9, Дэмжлэг үзүүлэх тухай-3, Шагнаж урамшуулах тухай-5, Хүүхэд үрчлэх тухай-1, 2019 оны төсвийн сар улирлын хуваарь өөрчлөн батлах тухай-1, Цахилгаан дамжуулах агаарын шугам байгуулах газрын байршил тогтоох тухай-1, Авто машины хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах тухай-1, Э.Отгонцэцэгт асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай-1, Ажил хүлээлцэх ажлын хэсэг томилох тухай-1, Тусгай зөвшөөрөл олгох тухай-1, Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж газар эзэмшүүлэх тухай-1, Ажлын хэсэг байгуулах тухай-4, Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай-1, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай-2, Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай-1, Сумын Засаг даргын Б захирамж 2 Албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлэх тухай, В.Энхсолонгийг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлөх тухай, Тамгын газрын даргын А тушаал 15 Ажлын хэсэг байгуулах тухай-6, Үнэлгээний хороо байгуулах тухай-1, “Нутгийн захиргааны байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт”-ийн сургалт, арга хэмжээний зардалд хөрөнгө зарцуулах тухай-1, Хөрөнгө зарцуулах тухай-3, Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1, Хэвлэмэл хуудас хариуцсан ажилтанг томилох тухай-1, Албан хэрэг хөтлөлтийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1, Ботгоны урамшуулал олгох тухай-1, Б тушаал 4 С.Баярмаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулах тухай, Б.Цэнднадмидад буцалтгүй тусламж олгох тухай, Б.Ренчиндоржтой хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулах тухай, Х.Цоггэрэлийг ажилд томилох тухай

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

2019 оны 06 сарын 02-нд Статистикийн хэлтсийн мэдээ тайлан гаргах сургалтанд ХАА-н мэргэжилтэн Ч.Дүүрэнжаргал хамрагдсан. 2019 оны 06 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 105 албан бичиг хүлээн авснаас 51 бичиг нь хариутай. Хариутай бичгийг заасан хугацаанд шийдвэрлэсэн. Засаг дарга болон Тамгын газраас 117 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Хариутай 51 хариугүй 54–105 23 санал хүсэлт өргөдөл ирсэн. 14 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хаасан, 9 өргөдөл хугацаандаа явж байна. Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2019.05.29-30-нд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албанаас зохион байгуулсан “ШИНЭ БАГ” төслийн сургалтад 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд багийн 60 иргэн хамт хамрагдлаа. 2019.06.02-нд Статистикийн хэлтсийн мэдээ тайлан гаргах сургалтад Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл,хоршоо, газар тариалан хариуцсан бодлогын мэргэжилтэн Ч.Дүүрэнжаргал хамрагдсан.

2019.06.05-06-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулагдсан “Ногоон байгууламж, Хог хаягдлын менежмент “Хангайн бүсийн аймгуудын нэгдсэн зөвлөгөөнд Байгаль хамгаалагч Э.Нандинцэцэг хамрагдсан. 209.06.10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Эрүүл хотын сүлжээ олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулж буй "Эрүүл мэндийг дэмжих зан үйлийн өөрчлөлт" олон улсын сургалтад Эрүүл мэнд, спорт, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн Т.Ууганбаяр хамрагдлаа. 2019.06.14-нд "Хашаандаа сайхан амьдарья", "Утааг бууруулья", "Хогоо багасгая", "Жорлонгоо өөрчилъе" уриан доор "Царцаа Ногоон залуус" багийнхан Даланзадгад сумын Засаг даргын урилгаар хүрэлцэн ирж, сургалт хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Нийт 120 гаруй албан хаагч, иргэд оролцлоо. 2019.06.14-15-ны өдрүүдэд Үндэсний статистикийн хороо, аймгийн Статистикийн хэлтсээс зохион байгуулсан “Хүн ам орон сууцны тооллого болон хүн амын тоо”-ны сургалтад Засаг даргын орлогч, Статистик төрийн сангийн мэргэжилтэн, 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд хамрагдлаа. 2019.05.21-нд Аймгийн төв номын сантай хамтран ажиллах тухай сургалтад 8 багийн нийгмийн ажилтан хамрагдав. 2019.05.23-нд НТБ төвөөс зохион байгуулсан “Монголын нууц товчоо” номын хэлэлцүүлэгт 19 иргэн, нийгмийн ажилтны хамт оролцсон. 2019.05.24-нд Музейгээс зохион байгуулсан “Үлгэрийн цаг” үйл ажиллагаанд 8 багийн нийгмийн ажилтан 38 иргэний хамт амжилттай сайн оролцсон. 2019.05.24-нд

Өмнөговь аймаг Даланзадгад сумын Засаг Даргын 2019.03.29 а/64 захирамжийн дагуу бүх нийтийн их их цэвэрлэгээ зохион байгуулж найман баг нийт 22 тн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлүүлэн хогийн цэгт төвлөрүүлсэн. Мөн багийн 16 алба хаагчид хариуцуулсан 48 ААН-ийнхээ орчны хог цэвэрлэгээ, ногоон байгууламж, тохижилтод хувиарын дагуу хяналт тавин тайланг хүргүүлэв. Байгууллагын шуурхай хурлыг 3 удаа хуралдаж цаг үеийн ажил, чиг үүргийг өгч ажиллаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ
5 сарын 17-нд “Архидан согтуурал, мансуурал, донтолтоос урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулан ажлын хэсэг 1 удаа хуралдаж, төлөвлөгөө боловсруулан, 8 багийн архинаас хамааралтай иргэдийн судалгааг гаргасан. 6 сарын 07-нд Даланзадгад сумын Засаг дарга харьяа төсөвт байгууллага 6 сургууль, 10 цэцэрлэг, хүүхдийн шүдний кабинет, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдлага, менежер, арга зүйч нартай уулзаж, цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, тодорхой үүрэг чиглэл өгч ажиллаа. Аймгийн Эрүүл мэндийн газрын хамт олны “Ажилдаа ч дугуйтай-Аялахдаа ч дугуйтай” уриан дор эхлүүлсэн challenge-д Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон нэгдэж 25 албан хаагчид 50 хувийн хөнгөлттэй үнээр дугуй өглөө. 06 сарын 07-нд Даланзадгад сумын ЗДТГ, Буянт хүүхдийн зуслангийн захиргаа, хүүхдийн шүдний кабинетын эмч нарын уулзалт зохион байгуулж “Эрүүл шүд” хөтөлбөрийн хүрээнд зуслангийн 1, 2 дугаар ээлжид дараах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөгөө гаргасан. Үүнд: Хүүхдийн шүдний кабинетын эмч мэргэжилтнүүд "Буянт Хотхон" зусланд амрагч хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн талаар сургалт мэдээлэл хийхээр 2 ширхэг самбар, 150 ширхэг сурталчилгааны материал бүхий үзлэгийн карт боловсруулан хэвлүүлж зуны зуслангийн хугацаанд тогтмол байршуулахаар боллоо. Хүүхдийн шүдний кабинетын эмч, сувилагч нар "Буянт хотхон" зуслангийн 1 дүгээр ээлжийн амрагч хүүхдүүдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, *шүдний бүтэц, шүд цоорох шалтгаан, шүд цоорох эрсдэл ихтэй хоол хүнс, эрсдэл багатай багатай хоол хүнс, шүд угаах арга сэдвүүдээр сургалтыг онол дадлага хэлбэрээр зохион байгуулж 25 хүүхэд хамрагдлаа. "Буянт хотхон" хүүхдийн зуслангийн 2-р ээлж болох "Олон улсын хөтөлбөртэй ээлжид Даланзадгад хотын шилдэг тэргүүний хүүхдүүд амрахаар эрхийн бичгээ гардан авлаа. 2019.05.31-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Даланзадгад сумын “Шилдэг-100” хүүхдийг шалгаруулж батламжлах арга хэмжээг зохион байгууллаа. Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 05 сарын 15-ны өдрийн 5-1268 тоот “Сайханы сарлаг-2019 арга хэмжээнд оролцох тухай” албан бичиг, удирдамжийн дагуу сумын Засаг даргын 2019 а/109 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. “Сайханы сарлаг-2019” арга хэмжээнд 1, 4, 8 дугаар багийн нийт 68 сарлаг мөнгөн урамшуулалд хамрагдаж, тэмцээн уралдаанд амжилттай оролцож багийн дүнгээр 3-р байранд шалгарсан. Өмнөговь аймгийн Статистикийн хэлтсийн 2019 оны 05 сарын 20-ны өдрийн 25 тоот захирамжаар “Хагас жилийн мал тооллогын ажил зохион байгуулах тухай” албан бичгийн дагуу сумын Засаг даргын 2019 оны а/128 дугаар захирамжаар хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг сонгогдсон малтай өрхүүдийн байршлыг тогтоож, явах чиглэл, зураглал, ажлын төлөвлөгөө боловсруулж, мал тооллогын ажлын семинар, сургалтыг зохион байгуулж ажиллаа. Мал тооллогын үйл ажиллагааг 06 дугаар сарын 03-наас 06 дугаар сарын 08-ний өдөр хүртэлх хугацаанд 4 ажлын хэсэг ажиллаж малын тооны түүвэр судалгаагаар сумын хойд, урд, зүүн, баруун гэсэн 4 чиглэлд нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 1450 км явж тооллогод сонгогдсон малчин, мал бүхий 68 өрх, 2 аж ахуй нэгжийг бүрэн хамруулан ажилласан.

Сумын хэмжээнд 2019 оны хагас жилийн мал тооллогоор нийт 147931 толгой мал тоолуулсан нь 2018 оны жилийн эцсийн малын тоотой харьцуулахад 39045 толгой малаар буюу 35.8 хувиар өссөн дүнтэй байна.

Малчин өрхийн өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дархлааг сайжруулах зорилгоор нийт 510 хүнийг витаминжуулалтад хамруулсан бөгөөд мөн “Шим билэг”, “Энхийн хүслэн”, “Өнө орших” өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн их эмч 3, лаборант 3 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр анхан шатны үзлэг, оношилгоо, шинжилгээ, эхо, зүрхний цахилгаан бичлэг зэрэг хүн эмнэлгийн үйлчилгээг нийт 129 малчинд хүргэн ажиллаа.

209.06.16-нд Төвийн бүсийн хурдан морины уралдааныг Өмнөговьд аймгийн төв Даланзадгад хотноо зохион байгуулж уралдаанд: Доод 3 нас буюу хазаалан, шүдлэн, даага мөн эрлийз дунд нас, эрлийз даага хурдаллаа.

Мал эмнэлэг ариун цэврийн хяналт, үзлэг шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд сумын Засаг даргын 2019 оны А/95 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Золбин нохой устгалын ажилд өдөр тутмын хяналт тавьж нийт 354 нохойг устгаж газрын гүнд булж үе тус бүрд ариутгал устгалын бодис хийж гүйцэтгэсэн. 1, 2-р багийн нутаг дэвсгэрт Малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 5 цэгээр багийн хэсгийн байцаагч, мал эмнэлгийн хяналтын байцаагч нар явж хяналт шалгалт хийн зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллаа.

Бороо, үерийн усны улмаас бохирдсон 2 малын хашаа, 24-р цэцэрлэгийн гадна талбай болох нийт 1070м² талбайг тус тус ариутгаад байна.

Мал эмнэлгийн үзлэгт 22613 толгой мал болон төл хамрагдсан.

Үхсэн мал, амьтны сэг зэм устгах ажлыг зохион байгууллаа. Нийт гахай, нохой болон бод бог малын 410 гаруй сэг зэмийг устгаад байна.

2019 оны Худалдан авах авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас Гэр хороололд явган хүний замын тоог нэмэгдүүлэх, 25 дугаар цэцэрлэгийн хашааг засварлах ажлуудын тендерийг зарлаж нийтийн тээврийн зогсоолын засварын тохижилт, шинэ суурьшлын бүсийн шугам сүлжээг хэрэгжүүлэх, цагдаагийн газрын албан хаагчдын орон сууцны засвар, 4 дүгээр сургуулийн урлагийн заалыг тоног төхөөрөмжөөр хангах ажлуудын тендерийн нээлтүүдийг хийж тендер шалгаруулалтын шатандаа явж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн Тогтвортой амьжиргаа-3 төслийн үнэлгээ дүгнэлтийн ажлын хэсэгт ОНХС-н ажлыг дүгнүүлээ.

Даланзадгад сумын 3 дугаар багийн төвийн барилгын их засварын ажлыг эхлүүлэн гүйцэтгэлийн шатандаа явж байна.

Даланзадгад сумын төвийн нийтийн орон сууцны гадна тохижилт, тоглоомын талбай байгуулах ажлуудтай сумын ИТХ-н дарга, 3 дугаар багийн Засаг дарга ГХБХГ-н дарга, аймгийн ерөнхий архитектор, зураг төсөв зохиогч Эл Эй Ай Ди ХХК нар 4 удаа захиалагчийн хяналт тавьж ажиллаа.

Даланзадгад сумын услалтын системийг засварлах ажлын явц болон захиалагчийн хяналтыг 5 удаа хийсэн.

Т.Борын талбайг засварлан тохижуулах ажлын угсралтын ажилтай танилцаж өөрчлөх зайлшгүй шаардлагатай ажлуудыг зураг төсвийн байгууллага болон гүйцэтгэгч хяналтын инженертэй зөвшилцөж шийдвэрлэсэн.

Нийт багийн нутаг дэвсгэрт Камержуулалтын ажил хийж дууслаа. 6 дугаар багийн нутагт МТ колонкийн уулзвараас Соёл амралтын хүрээлэн хүртэлх Эрдэнэс таван толгой ХХК нэрэмжит гудамжны тохижилтыг Цэлмэг зам ХХК хийж гүйцэтгэж байна. 3 дугаар багийн нутагт хийгдэж буй 45, 46-р байр, 23-р байрнуудын гадна авто зогсоолын асфальт хийгдлээ.

Аймгийн төв болон байрнуудын гадуур байрлалтай 12 ширхэг хогийн сав /пүнкер/-ийг ариутгаж халдваргүйжүүлж ажиллаа.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хорих ангид хүмүүжиж байгаа хүмүүжигч нарын ар гэр үр хүүхдийг уулзуулах “Бүтэн зүрх” арга хэмжээг Говьсүмбэр аймгийн хорих 425 анги, ГБХЗХГ, аймгийн олон нийттэй харилцах албатай хамтран зохион байгууллаа.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эцэг, эхийн ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгаас зарлагдсан 128 төслийг хүлээн авч амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн шалгаруулах ажлын хэсэгт шилжүүллээ.

Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд

2019.05.27-нд Хариуцлагатай уул уурхай хэлэлцүүлэгт 8 багийн Засаг дарга 70 иргэний хамт оролцлоо. 2019.05.27-нд 8 багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үер усны холбоотой мэдээлэл, судалгааг сумын онцгой комисст хүргүүлж ажиллаа. 2019.06.14-нд “Даланзадгад хотын хөгжилд иргэдийн оролцоо” сэдэвт сургалтад 8 багийн 65 иргэнийг оролцууллаа. 1-р баг: 2019.05.26-нд 23-р цэцэрлэгт 2-5 нас, хөгжлийн бэрхшээлтэй 0-6 насны хүүхдүүдийн судалгааг гаргаж өгсөн. 2019.05.30-нд Аймгийн музейгээс амьжиргааны төвшин доогуур өрхийн 13 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гарын бэлэг гардуулсан. 2019.05.30-нд “Одонгоо зүүцгээ” одонтой ээжүүдийн баярын арга хэмжээг зохион

байгуулж нийт 330 эмэгтэйчүүд оролцлоо. 2019.05.30-нд Аймгийн Засаг даргын гарын бэлгийг 50 хүүхдэд гардуулан ажиллаа. 2019.06.07-нд Аймгийн ИТХ-ийн төлөөлөгч, аймгийн засаг даргын орлогч Х.Батболд нартай хамтран багийн ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын уулзалтыг зохион байгууллаа. 2-р баг: 2019.05.25-нд “Бид нэгдэж байна” Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах ажлыг байгуулж, нийт 71 эмэгтэйчүүд оролцлоо. 2019.05.30-06.01 Хүүхдийн баярыг угтан БТСГ-тай хамтран 100 буудалт даамны тэмцээн болон ахмадуудын хүлээн авалтын үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 88 иргэн хамрагдлаа. 2019.05.31-нд Аймгийн Засаг даргын гарын бэлгийг багийн зорилтот бүлгийн өрхийн 50 хүүхдэд гардуулан өглөө. 3-р баг: 2019.06.01-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан багийн ААН болон аймгийн Засаг даргын гарын бэлгийг нийт 300 хүүхдэд гардуулан өглөө. 6-р баг: 2019.05.26-нд Сумын онцгой комисстой хамтран багийн үерийн цэгүүдтэй танилцан шуурхай ажиллаа. 2019.05.31-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын болон багийн ААН-ийн гарын бэлгийг 205 хүүхдэд гардуулж, багийн ээжүүдийн хүлээн авалтыг зохион байгуулж 2 ээжийг алдаршуулж алдрыг тэмдэглэн. Нийт 40 ээж оролцлоо. 2019.06.02-нд 4-р байрны СӨХ байгуулах талаар тус байрны 30 гаруй өрхийн төлөөлөлтэй уулзалтыг зохион байгууллаа. 7-р баг: 2019.05.21-нд Багийн иргэдийн дунд “Scatt” Буудлагын тэмцээнийг зохион байгууллаа. Нийт 54 иргэн оролцлоо. 2019.05.30-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ижий Шүтээн” хүндэтгэлийн арга хэмжээг 8 дугаар багтай хамтран зохион байгуулж, нийт 350 гаруй ээжүүд оролцлоо. 2019.06.01-нд “Оюутын-Одод” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 70 гаруй тамирчид оролцлоо. 2019.06.01-нд аймгийн Засаг даргын гарын бэлгийг багийн зорилтот бүлгийн 70 хүүхдэд гардуулан өглөө. 8-р баг: 2019.06.01-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын болон багийн ААН-ын гарын бэлгийг 115 хүүхдэд гардуулан өглөө.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын 18 захирамж боловсруулагдан гарсан. /Газар эзэмшүүлэх тухай-3, хөрөнгө зарцуулах тухай-1, Зөвшөөрөл олгох тухай-1, цалин шинэчлэн тогтоох тухай-1, зөвлөл, ажлын хэсэг байгуулах тухай-5, тусгай зөвшөөрөл олгох тухай-2, гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай-2, аян зарлах тухай-1, иргэдийг шагнах тухай-1, дэмжлэг үзүүлэх тухай-1/

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Аймгийн хөдөлгөөнд багийн ажлын хэсэг 5 сарын 29,30,31-ны өдрүүдэд Багийн төвүүдэд үйл ажиллагаа явуулсан. Багуудын Иргэдийн нийтийн хурал зохион байгуулагдаж ОНХС-ийн 2020 оны саналыг эрэмлэх ажлыг зохион байгуулсан. 5 дугаар сарын 16-нд Баяндалай суманд болсон Улаан загалмайн сургалтанд 6 хүн хамрагдсан. 5 дугаар сарын 17-нд МАК нарийн сухайт уурхайн нээлттэй хаалганы өдөрлөг боллоо. 5 дугаар сарын 20-нд ИТХ, ЗДТГ-аас иргэдэд цаг үеийн мэдээлэл хийж соёлын төв үйл ажиллагаагаа тайлагнасан. 6 дугаар сарын 2-нд ЭМТ-өөс шүдний арчилгаа сургалтыг зохион байгууллаа. 6 дугаар сарын 8-нд Өмнөговь аймгийн ардчилсан намын Иргэдээ сонсоё иргэдтэй уулзалт мэдээлэл хийх хурал болсон.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Авто тээврийн хяналтын үзлэг 6 дугаар сарын 8,9-ны өдөр сумын төвд 10-ны өдөр Хоолт багийн төвд болж өнгөрсөн.

Дөрөв: Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил

Байгууллагын эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгуулж данснаас данс хооронд болон актлах хөрөнгийн жагсаалтын сумын өмч хамгаалах болон аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Сумаас зохион байгуулсан иргэн Д.Цэцэгсүрэнд туслах хандивын аянд нэгдэн 343000 төгрөгийн эд материалын тусламж үзүүлсэн.

ЦОГТ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Сумын Засаг даргын А захирамж – 18, төлөвлөгдөн гарсан байна. Газар зохион байгуулалттай холбоотой – 2, Санхүүтэй холбоотой – 4, Бусад – 10 захирамжуудыг батлан мөрдөн ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 10, үүнээс Ажлын хэсэг – 6, Санхүүтэй холбоотой – 4 тушаал гарган мөрдөж ажиллаж байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Гурван багийн хурал 2019.05.25,26,27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус хуралд нийтдээ 226 иргэн хамрагдаж цаг үеийн мэдээлэл, Хууль эрх зүйн сургалтуудыг хүргэж ажиллаа. Эх үрсийн баярын арга хэмжээний хүрээнд 2019.06.01-ний өглөө 05.40 минутанд ээжүүд алтан нар, хангай дэлхийдээ хүндэтгэл үзүүлж “Сүү өргөх” үйл ажиллагааг зохион байгуулж 38 ээж хамрагдлаа. 2019.06.03-ны өдөр Гүн өрмийн худаг эзэмшигч иргэдтэй уулзах “Өглөний цай” арга хэмжээг зохион байгууллаа. Уулзалтанд 16 иргэн хамрагдсан. 2019.05.20-ны өдөр Цагдаагийн хэсгээс Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан бөгөөд 18 иргэн хамрагдсан байна. Тус сургалтын хүрээнд оролцогчдоос тестын шалгалт авсан, АХА тэмцээн зохион байгуулав. АХА тэмцээнд түрүүлсэн иргэнд “А” ангилалын сургалтанд үнэ төлбөргүй суралцах эрхийн бичиг, амжилттай оролцсон 2 иргэнд 5 литр шатхуунаар тус тус шагнасан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

ЗДТГазар нь 2019.05.20-ны өдөр Төрийн албан хаагчдаа “Харилцан суралцах арга зүй” сургалтыг ЗДТГ-ын дарга, Архив, бичиг хэргийн эрхлэгч, Нийгмийн асуудал, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар хамтран зохион байгуулж 16 албан хаагч хамрагдлаа. 2019.05.27-ны өдрөөс 2019.07.19-ныг хүртэлх хугацаанд “Цэвэр орчин – Цэмцгэр Цогт-Овоо аян”-ыг амжилттай зохион байгуулж байна. “Өглөний гүйлт, дасгал” аяныг 7 хоног бүрээр байгууллага, хорооллууд идэвхтэй зохион байгуулж ажилласан бөгөөд аяны хугацаанд 30 өглөө 426 иргэн хамрагдсан дүнтэй байна. 2019.06.08-ны өдөр аймгийн Дугуйн холбооноос зохион байгуулсан “Дугуйн аялал” арга хэмжээнд оролцож, хүлээн авч хамтран дугуйгаар аяллаа. Сумаас 11 иргэн дугуйтай оролцлоо. 2019.06.16-ны өдөр “Энержи ресурс” ХХК-аас Цалантай оюутан хөтөлбөрт хамрагдаж буй 12 оюутантай хамтран ажиллах гэрээ байгууллаа. 2019.06.17-ны өдөр Архивын урьдчилсан шалгалтанд амжилттай шалгууллаа. 2019.06.19-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн” талаар Удирдлагын **академийн** судалгаанд Төрийн захиргааны болон төрийн үйлүчилгээний албан хаагчид хамрагдлаа. Мөн ярилцлагад 17 албан хаагч хамрагдсан.

ЦОГТЦЭЦИЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 3 удаа хуралдаж, 14 тогтоол гаргав. Засаг даргын захирамж А/17 Б/4, нийт 21 захирамж, Засаг даргын Тамгын газрын Тушаал А/20 Б/2 нийт 22 тушаал гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөлгөөн, сургалт, семинар, уулзалт

“Таван толгойн орд газраас Говьсүмбэрийн чиглэлд шороон замаар замбараагүй нүүрс тээвэрлэлт хийж буй асуудалтай холбогдуулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн өргөгтгөсөн хурлыг 4 багийн иргэдийн дунд нээлттэй хуралдаж, хурлын тэмдэглэл, малчдын захидал, гарын үсгийн хамт Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, УИХ-ын гишүүн Л.Энхболд нарт уламжлан хүргүүлэв. 4 багийн хурлыг зохион байгуулж ОНХС-ын хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлын эрэмбэлсэн урьдчилсан жагсаалтыг оруулж танилцуулсан ба ГХБХБХМэргэжилтэн малчдад өвөлжөөний газар эзэмших, газрын харилцааны талаар, ХАА мэргэжилтнүүд “Хадлан тэжээл-2019” аяны талаар малчид, иргэдэд мэдээлэл хүргэсэн. Лектор Чилаа /Г.Баньдцэрэн/, сэтгэл судлаач Г.Наранбаатар нар Сийрст, Өгөөмөр багуудын урилгаар ирж гэр бүлийн харилцааны талаар иргэд олон нийтэд илтгэл тавив. Засаг даргын

өглөөний цай уулзалтыг нийт 2 удаа зохион байгуулсан, Таван толгой цахилгаан станц барих судалгааны баг ард иргэдтэй уулзалт хийж санал асуулга явуулав.ТАЗ-өөс зохион байгуулсан сургалтад 3, УЗН дунд шатны чуулганд 1,Төрийн байгууллага дахь жендерийн тэгш байдал сургалтанд 2, АЗ сургалтанд 6 хүн, Боловсролын байгууллагын 11, эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд салбарын сургалтанд хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд 5 хүн, Зорилтот бүлгийн 30 иргэн, 2 удаа нийт 50 иргэнд Төсөл хэрхэн бичих талаарх сургалт зохион байгуулсан. ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Бямдадорж 5 хүний бүрэлдэхүүнтэй ирж, эрүүл мэндийн байгууллагатай танилцаж ярилцлага уулзалтыг зохион байгууллаа. Үр дүн: Жендерийн хороо байгуулагдаж, дотооддоо болон иргэд олон нийтэд сургалт хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. 120 гаруй төрийн албан хаагч УЗН-д шинээр элссэн. Ирсэн төслүүдийн гүйцэтгэл сайн дэмжлэг авах хувь эрс нэмэгдсэн.

Гурав.Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Сумын төсвийн орлогын эхний үлдэгдэл 718,251.6 мянган төгрөг орон нутгийн орлого 357,808.0 мянган төгрөгний төлөвлөгөөтэйгөөс 305,999.6 мянган төгрөг орж төсвийн орлого 86%-иар биелж 14%-ын тасралттай байна, Орон нутгийн төсвийн байгууллагуудад олгосон санхүүжилт 707,226.0 мянган төгрөг орон нутгийн төсвийн орлогын үлдэгдэл 314,647.5 мянган төгрөг байна. ОНХС хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний 5-р сард 1,009,919.8 мянган төгрөгийн нийт 19 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөнөөс гэрээ байгуулсан 5, гэрээний дүн 322,528.5 мянган төгрөг, зарлагдсан тендер 3 80,347.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, зарлагдаагүй байгаа 459,599.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 тендер байна. ОНХСангийн цахим санал асуулга явуулж дүнг нэгтгэв. Архивын урьдчилсан үзлэгт сонгогдсон байгууллагууд хамрагдсан.

Ахмад настны эргэн төлөгдөх нөхцөлтэй 3 сая төгрөгний 2 төсөл, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр” 2 төсөл, Хүнсний ногоо бүлгээр тариалах 2 төсөл дэмжигдсэн. Ажил идэвхитэй хайгч 205 иргэнийг бүртгэж 36 иргэнийг ажлын байранд зуучилсан.

6-р цэцэрлэгийн гадна талбайн хашааг 34 сая төгрөгөөр /ОНХО/ барьж гүйцэтгэж хүлээн авав. Т.Борын нэрэмжит сургуулийн гадна дотор их засварын ажлыг эхлүүлэв. Тухайн сард Улсын шалгалт, анги дэвших шалгалт, төгсөлт, ЭЕШ зэрэг ажил зохион байгуулсан байна. 7-р цэцэрлэгийн Туслах тогооч 3. Энхзаяа нь Олон улсын тогооч нарын тэмцээнд амжилттай оролцож 3-р байр эзэллээ. Хүүхэд хөгжлийн түлхүүр хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр зуслан 5 хоногийн хугацаатай ажиллуулсан ба 2 сургуулиас нийт 22 дунд ангийн хүүхэд хамрагдаж уламжлалт зан заншил, мал адгуулах, цагаан идээ боловсруулах арга туршлагаас суралцав. Цэцэрлэг, сургуулиуд эрдмийн баяраа тэмдэглэв. Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, ихрүүдийн баярын тэмцээн уралдааныг төрийн байгууллагуудтай хамтран авч амжилттай зохион байгууллаа. / үйл ажиллагааны хүрээнд 110 хүүхдийн бүрэлдэхүүнтэй Аз жаргалтай хүүхэд нас сургууль цэцэрлэгийн насны хүүхдийн тоглолт, 3*3 сагсан бөмбөгийн тэмцээн дугуйн уралдаан зэргийг амжилттай зохион байгууллаа/. Сумын хэмжээнд нийт 7,6 га талбай 22 хүлэмжинд төмс хүнсний ногооны тариалалт хийсэн ба төсвийн байгууллагууд хэрэгцээт төмс хүнсний ногоогоо дотоод нөөц бололцоогоо ашиглан тариалав. Таван толгойн орд газраас Гашуун сухайт боомт чиглэлийн зам дагуух худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хяналт хийлээ. УНТЭ-н мэс заслын тасаг , ДЭМБ-ийн Мэс заслын , Яаралтай тусламжийн зохицуулах төв, Австралийн элчин сайдын яамны “Мэс заслын тусламж үйлчилгээг чадавхжуулах “ төслийн хүрээнд 22 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олон 2 хоног ажиллаж 17 хүнд дурангийн хагалгааг амжилттай хийж гүйцэтгэлээ. Мөн үүний зэрэгцээ ажлын байран дээрх дагалдан сургалтыг сум дундын эмнэлэг, энерги ресурсс, ханбогд сумын эмч мэргэжилтангүүдэд 3 хоног зохион байгууллаа. Дутуу нярайд амьдрал бэлэглэе аяныг зохион байгуулж нийт 8 байгууллагаас 578420 төгрөгний хандив цуглуулав. “Улаанбурхан Улаануудын эсрэг” нэмэлт дархлаажуулалтанд ЕБС-ын 1133 хүүхдийг хамруулсан. Жил бүрийн 06 сарын 14-ны өдрийг дэлхий нийтээр "Дэлхийн цусны донорын өдөр" болгон тэмдэглэж ирсэн бөгөөд ИТХ, УЗАШХ-оос Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар мэдлэгийг дээшлүүлж, бусдын амь насыг аврахын төлөө цусаа бэлэглэдэг ачтан доноруудаа

талархал илэрхийлж урамшуулав. Сум дундын эмнэлэг, Банкуудын нээлттэй хаалганы өдөр болов. Цахилгаан хангамжийн эх үүсврийн трансформаторуудын тос солих , засвар үйлчилгээ хийлээ.

Дөрөв : Багт хийгдсэн ажлууд

Багийн хурал, мал тооллого, шүлхийн эсрэг вакцин 4 багт хийж, Сийрст баг Энгэр цагаан Овоо, Цэций хайрханы тахилга, адуучин тэмцээн зохион байгуулав.